



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 47/18

Улаанбаатар хот

**Эзэмшиж буй газрын зориулалт  
өөрчлөх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3 дахь заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны А/25 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/451 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зориулалт өөрчлүүлэхээр хүсэлт гаргасан 2 (нэг) иргэний газрын зориулалтыг хавсралтад зааснаар өөрчилсүгэй.

2.Газрын зориулалт өөрчилсөн иргэдтэй холбогдох хууль тогтоомж, эрхийн актын дагуу гэрээ байгуулж, гэрчилгээ олгон, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд даалгасугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Газар зохион байгуулалтын албаны даргын 2025 оны А/20 дугаар тушаалын 14, 15 дугаартай Б.Мижидсамданд хамаарах заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД